ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/55/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Цэрэнханд<br>Утас: 99086371 Цахим хаяг:tserenkhandd@audit.gov.mn<br>Аудитор: Б.Цэвэлмаа<br>Утас: 99026016 tsevelmaab@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


ГАА-2026/055/НА-СТА-ТШЗ

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.04 № 93

танай ____________ -ны № ____________ -т

БАЯН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ч.БОЛДБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 878 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 2,411,196.3 мянган төгрөгийн иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. Байгууллагын даргын 2025 оны А/29 дугаар тушаалаар цаашид ашиглах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан 39,038.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассан байна.

**Аудитын гол асуудал**

Орон нутгийн төсвөөс 988,313.8 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батласнаас 970,821.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тайлант оны эцэст 10,626.8 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн, 45,111.8 мянган төгрөгийн шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын, нийт 55,738.6

82250500248

мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Мөн Сангийн яамнаас гүйлгээ хийх эрх хязгаарласантай холбоотойгоор 51,892.3 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан байна.

**Бусад асуудал**

Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 138 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж 90.7 хувьтай үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан СТ-1

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **33** | **АВЛАГА** | 123,932,495.56 | 55,738,566.32 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 90,196,012.00 | 10,626,762.00 |
| **335** | **Бусад авлага** | 33,736,483.56 | 45,111,804.32 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 33,736,483.56 | 45,111,804.32 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 397,423,959.65 | 365,164,208.25 |
| **354** | **Хангамжийн материал** | 203,593,959.65 | 170,984,208.25 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,693,075.00 | 1,243,075.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 201,900,884.65 | 169,741,133.25 |
| 35600 | Мал амьтад | 193,830,000.00 | 194,180,000.00 |
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **521,356,455.21** | **420,902,774.57** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,680,674,974.56 | 4,237,363,475.43 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,618,146,974.52 | 4,172,481,243.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,154,987,238.25 | 3,637,791,414.25 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (348,031,429.03) | (417,407,243.31) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 200,350,000.00 | 235,250,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (53,610,000.02) | (71,626,666.72) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 403,403,272.00 | 468,092,135.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (170,178,718.53) | (13 2,288,506.32) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 250,897,749.00 | 258,301,749.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (66,037,942.90) | (90,395,674.90) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 196,361,037.00 | 204,361,037.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (9,994,231.25) | (30,097,001.58) |
| 39217 | Ном | 60,000,000.00 | 110,500,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 62,528,000.04 | 64,882,232.08 |
| 39301 | Програм хангамж | 2,030,000.00 | 2,030,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (405,999.96) | (811,999.92) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 60,904,000.00 | 63,664,232.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,680,674,974.56** | **4,237,363,475.43** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,202,031,429.77** | **4,658,266,250.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,657,380.00 | 51,892,323.49 |
| **413** | **Өглөг** | 3,657,380.00 | 51,892,323.49 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 3,657,380.00 | 9,680,709.26 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 11,211,614.23 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 31,000,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 31,000,000.00 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,657,380.00** | **51,892,323.49** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,198,374,049.77 | 4,606,373,926.51 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 292,184,453.65 | 292,184,453.65 |
| 51101 | Өмч: - төрийн | 292,184,453.65 | 292,184,453.65 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,898,193,338.94 | 4,306,193,215.68 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,514,445,106.85 | 1,898,193,338.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 383,748,232.09 | 2,407,999,876.74 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 7,996,257.18 | 7,996,257.18 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,198,374,049.77** | **4,606,373,926.51** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,202,031,429.77** | **4,658,266,250.00** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан СТ-2

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,105,296,867.64** | **985,037,225.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 199,222,067.64 | 14,215,625.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 6,250,000.00 | 0.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 100,000,000.00 | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 92,657,127.00 | 13,970,625.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 314,940.64 | 245,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 906,074,800.00 | 970,821,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 906,074,800.00 | 970,821,600.00 |
| **12** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО** | **625,519,915.00** | **2,702,034,161.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 625,519,915.00 | 2,702,034,161.93 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,558,318.00 | 6,727,145.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,558,318.00 | 6,727,145.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 463,350,997.00 | 2,684,908,016.93 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 155,610,600.00 | 10,399,000.00 |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,730,816,782.64** | **3,687,071,386.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,336,708,108.90** | **1,271,257,751.99** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,256,066,171.26 | 1,206,541,002.07 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 636,308,200.10 | 698,186,207.22 |
| 210101 | Үндсэн цалин | 396,705,978.21 | 300,874,239.12 |
| 210102 | Нэмэгдэл | 188,513,498.89 | 397,311,968.10 |
| 210104 | Урамшуулал | 51,088,723.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,882,236.88 | 90,760,125.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,331,397.05 | 62,188,985.09 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,274,282.01 | 6,968,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,597,210.37 | 4,180,140.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,137,141.07 | 3,484,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,542,206.38 | 13,937,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,619,189.32 | 39,386,813.31 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,619,189.32 | 9,475,454.91 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 29,911,358.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 44,427,550.00 | 67,990,529.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,555,150.00 | 3,665,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,225,200.00 | 19,798,628.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,348,400.00 | 1,694,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,500,000.00 | 1,500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,298,800.00 | 2,293,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 39,038,251.40 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 72,763,500.00 | 1,735,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,966,800.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 67,796,700.00 | 1,735,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 25,816,000.00 | 16,546,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 25,816,000.00 | 16,546,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 41,110,508.70 | 46,129,596.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,696,480.00 | 45,163,480.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 700,000.00 | 400,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 143,844.70 | 129,756.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 100,000.00 | 200,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 590,000.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 242,684.00 | 236,360.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 637,500.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 352,138,986.26 | 245,806,730.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 133,735,200.00 | 16,934,573.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,980,000.00 | 1,117,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 216,423,786.26 | 227,754,757.86 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 80,641,937.64 | 64,716,749.92 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52,020,750.25 | 1,500,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 50,320,750.25 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,700,000.00 | 1,500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 28,621,187.39 | 63,216,749.92 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,621,187.39 | 63,216,749.92 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,336,708,108.90** | **1,271,257,751.99** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | 394,108,673.74 | 2,415,813,634.94 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 10,360,441.65 | 1,513,758.20 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 0.00 | 6,300,000.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 10,360,441.65 | 7,813,758.20 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -10,360,441.65 | -7,813,758.20 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | 383,748,232.09 | 2,407,999,876.74 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан СТ-3 (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,148,690,904.64** | **1,081,960,382.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,558,318.00** | **6,727,145.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,558,318.00 | 6,727,145.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 6,558,318.00 | 6,727,145.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,558,318.00 | 6,727,145.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,142,132,586.64** | **1,075,233,237.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 236,057,786.64 | 104,411,637.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 6,250,000.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 100,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 92,657,127.00 | 104,166,637.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 37,150,659.64 | 245,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 906,074,800.00 | 970,821,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 906,074,800.00 | 970,821,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,132,574,108.64** | **1,031,411,382.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,132,574,108.64** | **1,031,411,382.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **961,736,159.00** | **956,067,870.08** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 632,650,820.09 | 705,887,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 194,000,000.00 | 307,264,578.88 |
| 210102 | Нэмэгдэл | 428,450,820.09 | 398,622,621.12 |
| 210104 | Урамшуулал | 10,200,000.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,882,236.89 | 88,235,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,600,082.75 | 60,360,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,089,999.18 | 6,968,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,794,155.49 | 3,484,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,218,000.00 | 3,484,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,179,999.47 | 13,937,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 4,619,189.32 | 37,896,399.08 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,619,189.32 | 7,985,040.68 |
| 210302 | Түлш, халаалт | - | 29,911,358.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 44,914,050.00 | 26,650,778.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,555,150.00 | 2,879,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,225,200.00 | 17,877,428.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,348,400.00 | 1,694,700.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,500,000.00 | 1,500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,785,300.00 | 2,699,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,327,700.00 | 3,277,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,300,800.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 15,026,900.00 | 3,277,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 25,816,000.00 | 16,546,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 25,816,000.00 | 16,546,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 41,110,508.70 | 58,766,096.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,696,480.00 | 57,799,980.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 700,000.00 | 400,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 143,844.70 | 129,756.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 100,000.00 | 200,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 590,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 242,684.00 | 236,360.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 637,500.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 113,415,654.00 | 18,808,197.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 111,435,654.00 | 17,690,797.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,980,000.00 | 1,117,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **170,837,949.64** | **75,343,511.92** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52,020,750.25 | 1,500,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 50,320,750.25 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,700,000.00 | 1,500,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 118,817,199.39 | 73,843,511.92 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 118,817,199.39 | 73,843,511.92 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **16,116,796.00** | **50,549,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **16,116,796.00** | **50,549,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **16,116,796.00** | **50,549,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 16,116,796.00 | 50,549,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 16,116,796.00 | 50,549,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(16,116,796.00)** | **(50,549,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан СТ-4

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 292,184,453.65 | 7,996,257.18 | 1,514,445,106.85 | 1,814,625,817.68 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **292,184,453.65** | **7,996,257.18** | **1,514,445,106.85** | **1,814,625,817.68** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 383,748,232.09 | 383,748,232.09 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **292,184,453.65** | **7,996,257.18** | **1,898,193,338.94** | **2,198,374,049.77** |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **292,184,453.65** | **7,996,257.18** | **1,898,193,338.94** | **2,198,374,049.77** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **292,184,453.65** | **7,996,257.18** | **1,898,193,338.94** | **2,198,374,049.77** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 2,407,999,876.74 | 2,407,999,876.74 |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **292,184,453.65** | **7,996,257.18** | 4,306,193,215.68 | 4,606,373,926.51 |

## 2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан СТ-4-1

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **995,313,800.0** | **914,331,995.08** | **80,981,804.92** | **92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 995,313,800.0 | 914,331,995.1 | 80,981,804.9 | **92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 992,813,900.0 | 912,831,995.08 | 79,981,904.9 | **92** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 705,887,200.0 | 705,887,200.00 | - | **100** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 239,488,000.0 | 307,264,578.88 | (67,776,578.9) | **128** |
| 210102 | Нэмэгдэл | 466,399,200.0 | 398,622,621.12 | 67,776,578.9 | **85** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,235,900.0 | 88,235,900.00 | - | **100** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,360,500.0 | 60,360,500.00 | - | **100** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,968,900.0 | 6,968,900.00 | - | **100** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,484,400.0 | 3,484,400.00 | - | **100** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,484,400.0 | 3,484,400.00 | - | **100** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,937,700.0 | 13,937,700.00 | - | **100** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,000,000.0 | 37,896,399.08 | 1,103,600.9 | **97** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,000,000.0 | 7,985,040.68 | 14,959.3 | **100** |
| 210302 | Түлш, халаалт | 31,000,000.0 | 29,911,358.40 | 1,088,641.6 | **96** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 37,625,000.0 | 25,270,600.00 | 12,354,400.0 | **67** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,000,000.0 | 2,643,900.00 | 356,100.0 | **88** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,600,000.0 | 16,952,500.00 | 10,647,500.0 | **61** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,525,000.0 | 1,514,700.00 | 1,010,300.0 | **60** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,500,000.0 | 1,500,000.00 | - | **100** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,000,000.0 | 2,659,500.00 | 340,500.0 | **89** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,500,000.0 | 3,277,300.00 | 15,222,700.0 | **18** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.0 | - | 2,500,000.0 | **0** |
| 210604 | Урсгал засвар | 16,000,000.0 | 3,277,300.00 | 12,722,700.0 | **20** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 16,546,000.0 | 16,546,000.00 | - | **100** |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,546,000.0 | 16,546,000.00 | - | **100** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 63,690,000.0 | 21,736,096.00 | 41,953,904.0 | **34** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 62,540,000.0 | 20,769,980.00 | 41,770,020.0 | **33** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.0 | 400,000.00 | - | **100** |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.0 | 129,756.00 | 170,244.0 | **43** |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200,000.0 | 200,000.00 | - | **100** |
| 210807 | Газрын төлбөр | 250,000.0 | 236,360.00 | 13,640.0 | **95** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23,329,800.0 | 13,982,500.00 | 9,347,300.0 | **60** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,784,900.0 | 12,865,100.00 | 7,919,800.0 | **62** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,544,900.0 | 1,117,400.00 | 1,427,500.0 | **44** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,499,900.00 | 1,500,000.00 | 999,900.00 | **60** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,499,900.0 | 1,500,000.00 | 999,900.0 | **60** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,499,900.0 | 1,500,000.00 | 999,900.0 | **60** |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **995,313,800.0** | **914,331,995.08** | **80,981,804.9** | **92** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 988,313,800.0 | 909,868,256.47 | 78,445,543.5 | **92** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 988,313,800.0 | 909,868,256.47 | 78,445,543.5 | **92** |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 7,000,000.0 | 4,463,738.61 | 2,536,261.4 | **64** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,000,000.0 | 4,463,738.61 | 2,536,261.4 | **64** |

### 2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-Нэмэлт санхүүжилт СТ-4-2

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **93,784,875.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 93,784,875.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 93,784,875.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,380,178.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 235,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 924,928.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 40,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 87,579,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 87,579,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,825,697.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,825,697.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 93,784,875.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 93,539,875.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 245,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**3.1** Аудитаар нийт 4,798.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналын алдааг[1] илрүүлж аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

**Залруулсан алдаа:**

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Шүүхийн шийдвэрийн цалингийн нөхөн олговрын цалингийн авлагыг 695.7 мянган төгрөгөөр илүү,
- Үндсэн хөрөнгөд барилга, байгууламжийг 1,838.0 мянган төгрөгөөр илүү, машин тоног төхөөрөмжийг 774.5 мянган төгрөгөөр дутуу,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд гэрэл цахилгааны зардлыг 1,490.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг тус тус залруулав.

Аудитаар залруулагдаагүй 48,813.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 43,346.5 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг бус, 5,466.5 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үзсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 48,813.0 мянган төгрөгийн 5 зөрчил[2] илэрч 2 албан шаардлага, 3 зөвлөмж, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид 1 зөвлөмж хүргүүллээ.

### 3.2 Албан шаардлага

1. Бараа материалын дансанд бүртгэлтэй 5,850.0 мянган төгрөгийн 9 толгой үхэр, 10,440.0 мянган төгрөгийн 116 толгой хонь, 8,750.0 мянган төгрөгийн 125 толгой ямаа, 2,400.0 мянган төгрөгийн 30 толгой хонь, нийт 27,440.0 мянган төгрөгийн малын малжуулалтын гэрээний хугацаа дууссан, дараагийн айлд хүлээлгэж өгөөгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", Малжуулалтын гэрээний 3-т малын гэрээ дуусмагц дараагийн өрхөд үл маргах журмаар хүлээлгэн өгнө гэж гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Малжуулалтын гэрээний дагуу малыг дараагийн айлд шилжүүлэхгүй байгаа зөрчлийг арилгах

2. Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөр 11,375.3 мянган төгрөгийг төсвөөс төлсөн боловч буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т "Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авч ажиллах

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой**

1. Илрүүлэлт: Төсөвт тусгагдаагүй 4,531.2 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсөвт тусгаж батлуулах.

2. Илрүүлэлт: Нотариатын ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 1,283.0 мянган төгрөгийг хуульд заасан үндэслэлгүйгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндэслэлгүйгээр нэмэгдэл хөлс олгож байгаа зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх.

**Хоёр. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой**

3. Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж малчдын дундах гар бөмбөгийн тэмцээний шагналд 268.0 мянган төгрөг, сумын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээн, мөсний баярын шагналд 837.5 мянган төгрөг, адуучин тэмцээний шагналд 700.0 мянган төгрөг, ахмадын хойд бүсийн тэмцээний зардлын дэмжлэгт 1,500.0 мянган төгрөг, дэвжээ тэмцээний шагналд 500.0 мянган төгрөг, татвар төлөгчдийн тэмцээний шагналд 378.0 мянган төгрөг, нийт 4,183.5 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид заасniaас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, хууль тогтоомжоор хориглосон зардалд зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4.Аудитаар залруулсан алдаа, илэрсэн зөрчлийн нэгтгэл:** *(мянган төгрөгөөр)*

| **Аудитад хамрагдсан байгууллагын нэр** | **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс:** | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | **Дүн** |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Говь-Алтай Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газар | Бараа материалын дансанд бүртгэлтэй 5,850.0 мянган төгрөгийн 9 толгой үхэр, 10,440.0 мянган төгрөгийн 116 толгой хонь, 8,750.0 мянган төгрөгийн 125 толгой ямаа, 2,400.0 мянган төгрөгийн 30 толгой хонины, нийт 27,440.0 мянган төгрөгийн малын гэрээний хугацаа дууссан, дараагийн айлд хүлээлгэж өгөөгүй. | 1 | 27,440.0 | - | - | 1 | 27,440.0 | - | - |
| | Төсөвт тусгагдаагүй 4,531.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон. | 1 | 4,531.2 | - | - | - | - | 1 | 4,531.2 |
| | Нотариатын ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 1,283.0 мянган төгрөгийг хуульд заасан үндэслэлгүйгээр олгосон. | 1 | 1,283.0 | - | - | - | - | 1 | 1,283.0 |
| | Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөр 11,375.3 | 1 | 11,375.3 | - | - | 1 | 11,375.3 | - | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мянган төгрөгийг төсвөөс төлсөн боловч буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй. | | | | | | | | |
| | Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж малчдын дундах гар бөмбөгийн тэмцээний шагналд 268.0 мянган төгрөг, сумын аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээн, мөсний баярын шагналд 837.5 мянган төгрөг, адуучин тэмцээний шагналд 700.0 мянган төгрөг, ахмадын хойд бүсийн тэмцээний зардлын дэмжлэгт 1,500.0 мянган төгрөг, дэвжээ тэмцээний шагналд 500.0 мянган төгрөг, татвар төлөгчдийн тэмцээний шагналд 378.0 мянган төгрөг, нийт 4,183.5 мянган төгрөгийг зарцуулсан. | 1 | 4,183.5 | - | - | - | - | 1 | 4,183.5 |
| | **Нийт дүн** | **5** | **48,813.0** | **-** | **-** | **2** | **38,815.3** | **3** | **9,997.7** |

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |

| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ТШЗ | 1 | 1 | - | - | 1 | - | - | - |
| | **НИЙТ** | | | | | **1** | **-** | **-** | **-** |